



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/93/СТА-ТШЗ

Цахим хуудас:
Bayankhongor@audit.gov.mn
Баянхонгор хот
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70444470 Цахим хаяг:

Аудитор: Б.Бямбаа

Утас: 88050763 Цахим хаяг: Cpa_bymba@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	9
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15

Аудитын гэрчилгээ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

᠒᠐᠒᠐.᠐᠗.᠒7 № 1/᠒1/3

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

БУУЦАГААН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.ГАНЦЭЦЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020195

Тайлант онд Их эффiкт ХХК-ний 4150.0, Ди Эн Констракшн ХХК-ний 9000.0, Баярнамд 7294.3 мянган төгрөгийг нэхэмжлэл, анхан шатны баримтгүйгээр гүйлгээ хийсэн.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг баталсан 6 дугаар хавсралт"-ын "Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил" гэсэн төсвийн зарлагын ангиллыг зөрчиж цалингийн зардлаас байгууллагын даргын 2019.12.13-ны өдрийн А/30-тоот тушаалаар 15000,0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

Дээрх алдаа, зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

Аудитын тайлан

2.1. Оршил

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сургуулийн захирал Ж.Ганцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.21-нээс 2020.02.23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Хонгорын үр сад аудит ХХК-ны аудитор Б.Бямбаа хариуцаж хэрэгжүүлэв.

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хонгорын үр сад аудит ХХК-ны газарт 2020.02.19-ны өдрийн 18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь " Суралцагчдын сурлагын ахиц амжилтыг дээдлэн, сурах арга барил, төлөвшил хандлагыг эрхэм болгож олон нийтийн оролцоог дэмжихэд оршино " гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах
- Чанартай, хүртээмжтэй, ахицтай боловсролын үйлчилгээг хүргэх
- Багш, сурагч солилцоо хөтөлбөр боловсруулан ажиллах
- Эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх
- Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлэн ажиллах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ны Acolouc программ хангамж ашигладаг байна.

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1363122,4 мянган төгрөгөөс тооцон 27262,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 27262,4 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 117966.9 мянган төгрөгөөр буюу 0,9%-иар хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 36937,4 мянган, бараа материалын дансны үлдэгдэл 37942,3 мянган төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мөнгөн хөрөнгө	0,00	0,00	
Авлага	2110,0	3076.7	966.7
Урьдчилгаа	0,00	0,00	0,00
Бараа материал	90018.9	127961.2	37942.3
Үндсэн хөрөнгө	7068429,5	7105366,9	36937,4
Хуримтлагдсан элэгдэл	-256054.0	-449867.4	-193813.4
Нийт хөрөнгө	6904504.4	6786537.5	-117966.9
Өр төлбөр	589,8	0,00	-589,8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6903914,6	6786537,5	-117377,1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6904504.4	6786537.5	-117966.9

Авлага өмнөх оноос 966.7 мянган төгрөгөөр нэмэгдэж 3076.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан ба энэ нь өмнөх оны үлдэгдэл барагдаагүй байгаа тул тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.

Үндсэн хөрөнгө тайлант онд 36937,4 мянган төгрөгөөр өсч, 75628,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь БСШУЯамнаас 12919,7 мянган төгрөгийн үнэ төлбөргүй тоног төхөөрөмж өгсөн, төсвийн хөрөнгөөр 62709,2 мянган төгрөгийн хөрөнгө авсныг орлогод бүрэн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Бууцагаан сумын ИТХТ-чдийн 2019.05.16-ны 14 тоот тогтоолоор 38691,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 37942,3 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн болон засварын материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд 6904504,4 мянган төгрөгөөр тайлант хугацааны үр дүнгийн өөрчлөлтөөр нэмэгдсэн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 12 арга хэмжээнд зориулан 1207141,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1207141,0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Нийт зардлын 936393,0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, Орон нутгийн төсвөөс 270748,0 мянган төгрөгийн санхүүжилт авчээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1207141,0 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд 16545,4 мянган төгрөгийн орлого орсныг зориулалтын дагуу зарцуулсан байна..

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 чиглэлээр 28 эрсдэлд нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 53414,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 17869,7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 15100,0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, зөрчил арилгах давтан гаргахгүй байх 20444,3 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж өгөв.

Аудитаар дараах 32989,7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага өглөө. Үүнд:

1. Дотуур байрны Хүүхдийн хоолны зардлын төсвийн хэмнэлтээр худалдан авалт хийж тайлант хугацааны эцэст 2869,7 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлж үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т "Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Цалингийн зардлаас байгууллагын багш, ажилтан нарт даргын 2019.12.13-ны өдрийн А/30 тоот тушаалаар 15,0 сая төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг баталсан 6 дугаар хавсралт"-ын "Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил" гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргаж заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Тус сургуулийн захирал Ж.Ганцэцэгт Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 131/Ш32019/01815 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт Бууцагаан сумын ЕБС-ийн сургуулийн цалингийн зардлаас 15100,0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэхүү зөрчил нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв

Аудитаар биет бус хөрөнгийн ашиглалттай холбоотой зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2020 оны 2-р сарын 27-ны өдрийн 18 тоот албан шаардлага 15100,0 /арван таван сая нэг зуун мянган/ төгрөгний биелэлтийг хянах

2.13. Шилэн дансны мэдээлэл

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан байдал дараах байдалтай байна. Үүнд:

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	1	5	5
2	Хагас жил	4	4	4		

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	34	11	
5	Тухай бүр	8	96	78	27	
	Нийт	27	151	119	45	5

Улирал бүр мэдээлдэг төсвийн гүйцэтгэлийн мэдээний 3 дугаар улирлын мэдээ, тухай бүр мэдээлэх "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт"-ийн 8 дугаар сарын мэдээ, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах заасан мэдэгдлийн 8 дугаар сарын мэдээ зэрэг эдгээр 3 мэдээг хоцроосон байна. Мөн тухай бүр мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг-ийн 1-9 дүгээр сарын мэдээ мэдээллийг 2,3,4,8 дугаар мэдээг 10 сард нэмэлт зааварчилгаа өгсний улмаа дахин засварлан өөрчлөлт оруулсны улмаас хоцроосон байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1636,3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 19544,8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна. /Төсвийн тухай хуулийн 16.5.3.дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах, батлагдсан орон тоонд багтаан үйл ажиллагаагаа явуулж байх гэдэг зөвлөмж өгсөн байна/

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалтай” дүгнэлт

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Хөрөнгө данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: 2019.03.12-ны өдөр Их эффикт ХХК-ний 4150.0, 2019.11.12-ны өдөр Ди Эн Констракшн ХХК-ний 9000.0, 2019.12.25-ны өдөр Баярнямд 7294.3 мянган төгрөгийг нэхэмжлэл байхгүйгээр гүйлгээ хийсэн зөрчил аудитаар илэрлээ. Энэ талаар тодруулахад хөрөнгийг бүртгэлд орлого авсан байгаа боловч үүнийг аудитын явцад газар дээр нь очиж тулган баталгаажуулах боломжгүй байсан ба энэ талаар холбогдох санхүүгийн байгууллага шалгахад хөрөнгө тухайн үед байхгүй байсан гэсэн мэдээлэл ирсэн ба энэ асуудлаар аймгийн Цагдаагийн газар шалгагдаж байгаагаас үзэхэд худалдан авсан хөрөнгийг бодитоор үнэн зөв оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Мөн тухайн байгууллага нь худалдан авсан бараа материалын төлбөрийг хийхдээ Е баримтыг хэрэглэхгүй байгаа зөрчлүүд байна

1.2 Эрсдэл: *Хөрөнгө дутагдах, шамшигдах*

1.3.Өгсөн зөвлөмж: Сумын өмч хамгаалах комисс Их эффикт ХХК-иас 4150.0, Ди Эн Констракшн ХХК-иас 9000.0, иргэн Баярнямаас 7294.3 мянган төгрөгийн тус тус худалдан авсан хөрөнгөнд хэсэгчлэн тооллого хийж үр дүнг хэлэлцэн хариу ирүүлэх.

Цаашид анхан шатны баримтын бүрдэлгүй, бэлтгэн нийлүүлэгчийн Е баримтгүй гүйлгээ хийдэг явдлыг таслан зогсоох.

1.1. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвшөөрсөн

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Давсны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	92,128,933.88	131,038,042.88
33	АВЛАГА	2,110,000.00	3,076,783.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,110,000.00	3,076,783.00
35	БАРАА МАТЕРИАЛ	90,018,933.88	127,961,259.88
351	Түүхий эд материал	00.00	5,321,320.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	5,198,000.00
35130	Эм боох материал	00.00	123,320.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	1,253,300.00
354	Хангамжийн материал	90,018,933.88	121,386,639.88
35410	Бичиг хэргийн материал	547,120.00	2,383,120.00
35420	Аж ахуйн материал	60,788,437.07	60,788,437.07
35440	Түлш, шатах тослох материал	00.00	2,184,560.00
35450	Барилгын засварын материал	33,000.00	2,420,000.00
35460	Хүнсний материал	576,900.00	1,616,475.00
35470	Бусад хангамжийн материал	28,073,476.81	51,994,047.81
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,812,375,467.99	6,655,499,522.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,812,375,467.99	6,655,499,522.53
392	Биет хөрөнгө	6,736,789,842.99	6,579,996,397.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,368,271,178.17	6,405,928,891.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-212,400,517.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	200,143,167.36	180,262,796.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-190,561,007.70	-160,229,815.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	96,235,309.63	105,053,129.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	-62,112,493.87	-73,774,045.98
39216	Дуусаагүй барилга, байгууламж	301,816,000.00	301,816,000.00
39217	Ном	22,997,689.40	33,339,959.40
393	Биет бус хөрөнгө	75,585,625.00	75,503,125.00
39301	Програм хангамж	3,566,200.00	3,566,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,380,575.00	-3,463,075.00
39303	Бусад биет бус хөрөнгө	75,400,000.00	75,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,904,504,401.87	6,786,537,565.41
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,903,914,629.87	6,786,537,565.41
51	Засгийн газрын хувь оролцоо	6,903,914,629.87	6,786,537,565.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	763,215,984.63	763,215,984.63
51101	Өмч: - төрийн	763,215,984.63	763,215,984.63
512	Хуримтлагдсан үр дүн	3,856,466,609.70	3,739,089,545.24
51210	Өмнөх үеийн үр дүн	3,856,466,609.70	3,856,466,609.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-117,377,064.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,284,232,035.54	2,284,232,035.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,904,504,401.87	6,786,537,565.41

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	903,865,169.60	1,245,745,401.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,449,026.70	22,059,001.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,449,026.70	22,059,001.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,449,026.70	22,059,001.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,419,026.70	22,059,001.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,357,342.90	287,293,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	881,058,800.00	936,393,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,180,353.90	16,545,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,180,353.90	16,545,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	270,748,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	270,748,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,131,110,457.59	1,363,022,565.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,064,372,497.69	1,330,383,165.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,064,372,497.69	1,330,383,165.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528,905,390.00	670,318,302.11
210101	Үндсэн цалин	528,905,390.00	670,318,302.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,182,566.00	82,936,007.89
210201	Тэтгэврийн даатгал	45,432,839.00	57,129,126.89
210202	Тэтгэмжийн даатгал	5,291,656.00	6,538,302.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,233,326.00	5,230,640.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,020,433.00	1,276,176.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,204,312.00	12,761,763.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	154,844,000.00	262,063,440.00
210301	Гэрэл, цахилгаан	10,035,961.00	8,480,892.00
210302	Түлш, халаалт	137,920,000.00	245,139,440.00
210303	Цэвэр, бохир ус	6,888,039.00	8,443,108.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,683,697.00	6,382,790.90
210401	Бичиг хэрэг	690,150.00	1,554,134.00
210402	Тээвэр, шатахуун	2,408,302.00	2,896,676.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	363,100.00	808,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	105,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,924,145.00	1,018,980.00
2105	Нормативт зардал	56,382,945.00	60,093,560.00

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
210501	Эм. бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	174,180.00	539,480.00
210502	Хоол, хүнс	56,134,765.00	56,910,960.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	74,000.00	2,643,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,156,300.00	5,286,687.00
210604	Урсгал засвар	6,156,300.00	5,286,687.00
2107	Томилолт, зочны зардал	425,500.00	2,152,400.00
210702	Дотоод албан томилолт	425,500.00	2,152,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	363,450.00	5,002,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	363,450.00	4,602,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	245,428,649.69	236,147,277.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,946,610.00	3,689,243.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,593,140.00	53,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	232,888,899.69	232,405,034.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,737,959.90	32,639,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,429,289.00	32,639,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,741,000.00	26,079,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,211,300.00	3,380,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	3,180,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-227,245,287.99	-117,277,164.46
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	634,428,180.69	99,900.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,684,379.94	99,900.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-634,428,180.69	-99,900.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-861,673,468.68	-117,377,064.46

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	897,446,142.90	1,223,686,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	897,416,142.90	1,223,686,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	881,058,800.00	936,393,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,180,353.90	16,545,400.00
131104	Дээл шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,180,353.90	16,545,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	270,748,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	270,748,000.00

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	897,446,142.90	1,223,686,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	897,446,142.90	1,223,686,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	827,906,483.00	1,189,793,700.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	525,123,717.10	669,952,300.00
210101	Үндсэн цалин	428,300,217.10	528,426,376.00
210102	Нэмэгдэл	66,470,800.00	90,320,624.00
210104	Урамшуулал	30,352,700.00	51,205,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,641,011.00	84,769,000.00
210201	Тэтгэврийн даатгал	34,273,820.00	62,483,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,547,863.00	5,571,300.00
210203	ҮОМЦӨ-ний даатгал	6,593,544.00	4,438,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,766,418.00	1,132,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,459,366.00	11,142,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	154,844,000.00	264,248,000.00
210301	Гэрэл, цахилгаан	7,924,000.00	7,924,000.00
210302	Түлш, халаалт	137,920,000.00	247,324,000.00
210303	Цэвэр, бохир ус	9,000,000.00	9,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,792,607.00	12,110,300.00
210401	Бичиг хэрэг	883,150.00	1,811,000.00
210402	Тээвэр, шагахуун	1,944,300.00	2,144,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	573,157.00	1,895,400.00
210404	Ном, хэвлэл	691,900.00	1,368,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,700,100.00	4,710,800.00
2105	Нормативт зардал	59,285,994.00	62,268,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	399,070.00	662,800.00
210502	Хоол, хүнс	57,602,724.00	58,040,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,284,200.00	3,565,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,805,300.00	65,900,000.00
210602	Гавилга	00.00	20,900,000.00
210604	Урсгал засвар	2,805,300.00	45,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	425,500.00	2,152,400.00
210702	Дотоод албан томилолт	425,500.00	2,152,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,571,953.90	14,159,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,571,953.90	13,759,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,416,400.00	14,233,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,916,400.00	8,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,500,000.00	6,233,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,539,659.90	33,892,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,230,989.00	33,892,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,331,900.00	27,332,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,211,300.00	3,380,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	3,180,000.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахив үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	687,815,984.63	00.00	4,718,140,078.38	00.00	5,405,956,063.01
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	687,815,984.63	00.00	4,718,140,078.38	00.00	5,405,956,063.01
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-123,166,700.66	00.00	-123,166,700.66
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	763,215,984.63	2,284,232,035.54	3,856,466,609.70	00.00	6,903,914,629.87
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	763,215,984.63	2,284,232,035.54	3,856,466,609.70	00.00	6,903,914,629.87
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	763,215,984.63	2,284,232,035.54	3,856,466,609.70	00.00	6,903,914,629.87
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-117,377,064.46	00.00	-117,377,064.46
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	763,215,984.63	2,284,232,035.54	3,739,089,545.24	00.00	6,786,537,565.41

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	864,685,000.00	864,682,257.00	1,207,141,000.00	1,207,141,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	864,685,000.00	864,682,257.00	1,207,141,000.00	1,207,141,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	768,519,800.00	768,517,133.00	1,176,628,700.00	1,176,628,700.00

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	488,787,100.00	488,787,100.00	669,952,300.00	669,952,300.00
210101	Үндсэн цалин	391,963,600.00	391,963,600.00	527,899,700.00	528,426,376.00
210102	Нэмэгдэл	66,470,800.00	66,470,800.00	90,847,300.00	90,320,624.00
210104	Урамшуулал	30,352,700.00	30,352,700.00	51,205,300.00	51,205,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,561,100.00	53,561,100.00	84,769,000.00	84,769,000.00
210201	Тэтгэврийн даатгал	34,331,500.00	34,331,500.00	62,483,900.00	62,483,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,845,900.00	3,845,900.00	5,571,300.00	5,571,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,807,400.00	4,807,400.00	4,457,100.00	4,438,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	961,500.00	961,500.00	1,114,000.00	1,132,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,614,800.00	9,614,800.00	11,142,700.00	11,142,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,436,700.00	138,436,413.00	264,248,000.00	264,248,000.00
210301	Гэрэл, цахилгаан	7,836,700.00	7,836,413.00	7,924,000.00	7,924,000.00
210302	Түлш, халаалт	120,680,000.00	120,680,000.00	247,324,000.00	247,324,000.00
210303	Цэвэр, бохир ус	9,920,000.00	9,920,000.00	9,000,000.00	9,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,253,000.00	7,250,620.00	12,110,300.00	12,110,300.00
210401	Бичиг хэрэг	993,900.00	993,900.00	1,811,000.00	1,811,000.00
210402	Гээвэр, шатахуун	1,944,300.00	1,941,920.00	2,144,300.00	2,144,300.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	1,154,100.00	1,154,100.00	1,895,400.00	1,895,400.00
210404	Ном, хэвлэл	928,400.00	928,400.00	1,368,800.00	1,368,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,232,300.00	2,232,300.00	4,710,800.00	4,710,800.00
2105	Норматив зардал	63,719,800.00	63,719,800.00	62,268,500.00	62,268,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	492,300.00	492,300.00	662,800.00	662,800.00
210502	Хоол, хүнс	62,507,800.00	62,507,800.00	58,040,100.00	58,040,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	719,700.00	719,700.00	3,565,600.00	3,565,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,312,800.00	9,312,800.00	65,900,000.00	65,900,000.00
210602	Тавилга	00.00	00.00	20,900,000.00	20,900,000.00
210604	Урсгал засвар	9,312,800.00	9,312,800.00	45,000,000.00	45,000,000.00
2107	Томилголт, зочны зардал	796,100.00	796,100.00	2,152,400.00	2,152,400.00
210702	Дотоод албан томилголт	796,100.00	796,100.00	2,152,400.00	2,152,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хурламж	723,500.00	723,500.00	994,600.00	994,600.00

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит					
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	723,500.00	723,500.00	594,600.00	594,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	400,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5929700.00	5929700.00	14233600.00	14233600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,529,700.00	5,529,700.00	8,000,000.00	8,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	400,000.00	6,233,600.00	6,233,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96165200.00	96165124.00	30512300.00	30512300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,165,200.00	96,165,124.00	30,512,300.00	30,512,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,280,200.00	25,280,200.00	27,332,300.00	27,332,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,817,500.00	19,817,424.00	3,180,000.00	3,180,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	864,685,000.00	864,682,257.00	1,207,141,000.00	1,207,141,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	864,185,000.00	864,182,257.00	936,393,000.00	936,393,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлэгээс санхүүжих	864,185,000.00	864,182,257.00	936,393,000.00	936,393,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	270,748,000.00	270,748,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	270,748,000.00	270,748,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	61.00	61.00	61.00	61.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00	39.00	39.00
620003	Үйлчлэх ажилтан	21.00	21.00	21.00	21.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	268.00	262.00	263.00	261.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
------------	----------	----------	-----------

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		16545400
21	УРСГАЛ ЗАРДАЛ		16545400
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		16545400
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		16545400
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		16545400
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР  БЯМБАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

